



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



Монгол Улс дахь Тогтвортой хөдөө аж ахуй

Хамтын ажиллагааны төсөл

Төслийн тухай

Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл нь Монгол Улсын Засгийн газрыг хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн зорилгуудаа биелүүлэхэд нь дэмжиж, түүнчлэн хоёр орны хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн яриа хэлэлцээг эрчимжүүлэхийг зорьж байна.

Монгол Улсын Их Хурал (УИХ)-аас баталсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (2016-2025) болон УИХ-аас тус бодлогыг хэрэгжүүлэхээр 2016 онд шинэчлэн баталсан “Тариалангийн тухай” хууль нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын ирээдүйн хөгжлийн хандлага, эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Эдгээр бодлого, эрх зүйн баримт бичгүүдэд нэн тэргүүнд экологийн хувьд тогтвортой, эдийн засгийн үр ашигтай тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээгээ хангах, мөн экспортыг нэмэгдүүлэх гэх зэрэг зорилгуудыг дэвшүүлжээ.

Хөдөө аж ахуй нь Монгол улсын эдийн засгийн уламжлалт салбар бөгөөд 2017 оны эцсийн байдлаар, тус салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 13,3 хувийг үйлдвэрлэж, цаашид ч улам өргөжин хөгжиж, бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой салбар юм (ҮСХ, 2018).



Төслийн зорилго ба хамрах хүрээ



Төслийн зорилго нь хөдөө аж ахуйн холбогдох сэдвүүдээр Герман, Монголын хооронд харилцан туршлага солилцох, мэдлэг дамжуулах хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино. Түүнчлэн салбарын хууль, эрх зүйн болон байгууллагын бүтэц, зохион байгуулалтын орчныг боловсронгуй болгох, улмаар монголын хүнс, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулахыг зорино. Таримал ургамлын үр, сорт, үрийн аж ахуй, газар тариалангийн зохистой дадал болон эрсдлийн менежмент нь төслийн үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд юм.

Төслийн үйл ажиллагааны хэлбэрүүд:

- Тогтвортой хөдөө аж ахуйн бодлогын зөвлөгөө болон орчин үеийн шаардлагад нийцүүлэн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зөвлөх үйлчилгээ;
- Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудыг дэмжих (Тухайлбал: Төрийн захиргааны төв, хэрэгжүүлэгч, орон нутгийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, зөвлөх төв болон эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд);
- Төслийн хамтрагч талууд болон зорилтот бүлгүүдийг мэргэжлийн мэдээ, мэдээллээр хангах;
- Сонгосон сэдвүүдээр хурал, зөвлөгөөн, уулзалт ярилцлага зэрэг үйл ажиллагаанууд болон туршлага судлах аялалууд зохион байгуулах;
- Монголын хөдөө аж ахуйн салбарын удирдах болон мэргэжлийн боловсон хүчнийг мэргэшүүлэх, давтан сургалтуудаар чадавхижуулах зэрэг болно.

Хамтрагч талууд

Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн бодлогын түвшинд хамтрагч талууд нь Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам юм. Төслийг ИАК Аграр Консалтинг ХХК-ийн удирдлага дор АФС Консалтантс Интернейшнл ХХК болон ДЛЖ Интернейшнл ХХК-иуд хамтран хэрэгжүүлж байна.

Энэхүү төсөл нь салбарын шинжлэх ухааны байгууллагуудтай төслийн үндсэн сэдвүүдээр харилцан туршлага солилцох, мэдлэг, мэдээлэл дамжуулах зэргээр нягт хамтран ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургууль болон Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачидтай хамтран салбарын төрийн албан хаагчид, газар тариалангийн төлөөллүүдийг газар тариалангийн онолын мэдлэг болон практик арга туршлагаар ханган ажиллаж байна. Түүнчлэн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж буй бөгөөд эдгээр байгууллагууд нь мультипликаторын үүргийг гүйцэтгэж байна. Үүнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монголын тариаланчдын үндэсний холбоо, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв болон Төв Азийн хөрс судлалын холбоо зэрэг байгууллагуудыг нэрлэж болно.

Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас гадаад улс орнуудад хэрэгжүүлж буй бусад төсөл, хөтөлбөрүүдэд хамтран ажиллаж байгаа олон улсын зөвлөхүүдийг тус төсөлд урьж оролцуулснаар монголын шийдвэр гаргагчид болон эрдэмтэн судлаачид илүү өргөн хүрээний мэдээлэл авах боломжтой бөгөөд улмаар улс орнуудын хийгээд мэргэжлийн сэдвүүдийн хооронд уялдаа холбоог дэмжиж байна.



Харилцах

Герман Улсад



Мари Кюнстлинг

Төслийн захирал

ИАК Аграр Консалтинг ХХК

Борнаэр гудамж 16

04288 Лайпциг

Утас: +49 34297 71419

Факс: +49 34297 71484

Гар утас: +49 173 53 35 245

И-мэйл:

m.kuentling@iacleipzig.de

Вэб: www.iacleipzig.de



Ганболдын Ганцэцэг

Төслийн зохицуулагч

ИАК Аграр Консалтинг ХХК

Борнаэр гудамж 16

04288 Лайпциг

Утас: +49 34297 71423

Факс: +49 34297 71484

Гар утас: +49 173 31 53 635

И-мэйл:

g.ganbold@iacleipzig.de

Вэб: www.iacleipzig.de

Монгол Улсад



Др. Алфред Катер

Төслийн удирдагч

Засгийн газрын IXа байр, 501

Энхтайвны өргөн чөлөө 16а

13381 Улаанбаатар

Утас: +976 9552 0608

И-мэйл:

a.kather@iacleipzig.de

Вэб: www.dmknl.de



ЭРХЛЭН ГАРГАСАН

Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам
(ХХХААЯ)
Реферат 624
10117 Берлин

ГФА Консалтинг Групп ХХК
Валл гудамж 15
10179 Берлин

ХЭВЛЭСЭН ОГНОО

2019 оны 4 сар

ЭХ БЭЛТГЭЛ

design.idee, Büro für Gestaltung, Erfurt

ТЕКСТ

ИАК Аграр Консалтинг ХХК

ХЭВЛЭЛ

ХХХААЯ

ГЭРЭЛ ЗУРАГ

ИАК Аграр Консалтинг ХХК

Энэхүү хэвлэлийн материалыг ХХХААЯ-с санхүүжүүлэв. Аливаа сонгуулийн болон намын сурталчилгааны ажилд ашиглахыг хориглоно.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи хаягаас авна уу

www.bmel-kooperationsprogramm.de болон
www.dmkn1.de

Энэхүү төсөл MNG 19-01 нь Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамны санхүүжилтээр ГФА Консалтинг Групп ХХК-аар дамжуулан хэрэгжиж байна.

